



# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

20 18 он 04  
сарын 19 өдөр

Дугаар ЗГ-1/76

Улаанбаатар  
хот

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА М.ЭНХБОЛД ТАНАА

Хуулийн төслийд өргөн мэдүүлэх тухай

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай, Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн дэмжээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

Монгол Улсын Ерөнхий сайд

У.ХҮРЭЛСҮХ



20072



МОНГОЛ УЛС  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20<sup>18</sup>.04.13  
онд дугаар  
сарын 13.-ны өдөр

Дугаар  
Хагт/751

Улаанбаатар-12  
Утас: 260817  
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  
Ц.ЦОЛМОН ТАНАА

Хуулийн төслүүд өргөн мэдүүлэх  
хугацааг товлох тухай

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай, Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслүүдийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлэх хугацааг товлож өгнө үү.

Монгол Улсын сайд  
Засгийн газрын Хөрөг  
эрхлэх газрын дарга

Г.ЗАНДАНШАТАР



000783



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,  
ДОТООД ХЭРГИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг.  
Худалдааны гудамж 6/1, Засгийн газрын V байр.  
Утас/Факс: (976-51) 26 75 33, E-mail: foreign@mojha.gov.mn  
<http://www.mojha.gov.mn>

2018. 04. 18 № 1-1/1760  
танаи 2018. 04. 06 -ны № 01/2134-т

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ  
ЖУУУЛЧЛАЛЫН САЙД Н.ЦЭРЭНБАТ  
ТАНАА

Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасны дагуу Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай, Нэмэгдсэн өргтийн албан татвараас чөлөөлөх тухай тухай хуулийн төслийд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.



08 1162  
Doc. uam a5.2017



БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ  
ЖУУЛЧЛАЛЫН САЙД Н.ЦЭРЭНБАТ  
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,  
Утас/факс: (976-51) 26-74-68, <http://www.mof.gov.mn>

2018.04.14 № 618085  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Зөвшөөрөл олгох тухай

Импортоор оруулж байгаа тутамд чиглэлийн нимгэн давхаргатай хавтан /OSB/, стандартын дагуу хийгдсэн, угсархад бэлэн модон барилгын угсармал хийцийг гаалийн албан татвараас 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд гаалийн албан татвараас чөлөөлөх тухай, ойжуулалт, цэцэрлэгжүүлэлт, ойн аж ахуйн арга хэмжээний ажил болон импортоор оруулж байгаа тутамд чиглэлийн нимгэн давхаргатай хавтан /OSB/, стандартын дагуу хийгдсэн, угсархад бэлэн модон барилгын угсармал хийцийг нэмэгдсэн өртгийн албан татвараас 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд чөлөөлөх тухай хуулийн төслийд Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7-д заасныг үндэслэн Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрлийг үүгээр олгож байна.

Хүндэтгэсэн,




Ч.ХҮРЭЛБААТАР

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭС

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн хуралдааны 12 дугаар тэмдэглэлд:

“I. ХЭЛЭЛЦСЭН нь: Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай, Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслүүдийг хэлэлцэн дэмжээд

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай, Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслүүдийг хэлэлцэн дэмжээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



## ГААЛИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

**Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага**

Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Монгол Улсад газар, түүний хэвлүй, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна." гэж, мөн зүйлийн 2 дахь хэсэгт "Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлүй, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн өмч мөн." гэж тус тус заасан.

Түүнчлэн Улсын Их Хурлын 2010 оны "Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал батлах тухай" 48 дугаар тогтоолын хавсралтын 3.5.3.3-т "Байгалийн ургамал, ойн дагалт нөөцийн экспорт болон ойн үндсэн ашиглалтын огтлолтыг бүрэн хориглож, ойн сангийн нөөцийг 2 хувиар нэмэгдүүлнэ" гэж, 3.5.3.4-т "Мод орлох технологи нэвтрүүлэхийг дэмжих, энэ төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж түлшний асуудлыг цогц байдлаар шийдэх, мод, модон бүтээгдэхүүний импортыг нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлнэ." гэж тус тус тусгажээ.

Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2013 оны 14 дүгээр тогтооолоор Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал болон Ойн тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор импортоор мод, модон материал оруулж ирж үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийн бизнесийг дэмжих, нэмэгдсэн өргтийн болон гаалийн албан татвараас чөлөөлөх, тэдгээрт хөнгөлөлттэй зээл олгох арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасан байна.

Улсын Их Хурлын 2015 оны "Төрөөс ойн талаар баримтлах бодлого батлар тухай" 49 дүгээр тогтоолд ойн нөхөн сэргээлт, ойжуулалтын хэмжээг ёсгөх замаар ойгоор бүрхэгдсэн талбайг нэмэгдүүлэх<sup>1</sup>, мод орлох бүтээгдэхүүний нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийн зориулалттай мод, модон материалын хэрэгцээг импортын modoор хангах бодлого баримталж, иргэдийн модон бүтээгдэхүүний хэрэгцээг ойн арчилгаа, цэвэрлэгээний зэрэг ойн экосистемд халгүй аргаар бэлтгэсэн modoор хангах<sup>2</sup>, тарьц, суулгац ургуулах дэвшилтэт шинэ технологи нэвтрүүлж, ойжуулалтын ажлын чанарыг сайжруулах<sup>3</sup>, ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээнд

<sup>1</sup> Төрөөс ойн талаар баримтлах бодлогын 2.2.1 дахь заалт.

<sup>2</sup> Төрөөс ойн талаар баримтлах бодлогын 3.2.2. дахь заалт.

<sup>3</sup> Төрөөс ойн талаар баримтлах бодлогын 3.1.5, 3.4.2 дахь заалт.

оруулах хөрөнгө оруулалтыг дэмжих хөшүүрэг, механизмыг бий болгох зэрэг арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлэхээр заасан.

Засгийн газрын санаачлагаар 2008-2016 онуудад Улсын Их Хурлаас ойг хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагааг дэмжих хүрээнд Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай (2008, 2013 онуудад) хуулийг<sup>4</sup> батлан хэрэгжүүлж иржээ.

Хууль		Татвараас чөлөөлөгдсөн зүйл
1	Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай  /2008-05-29/	Импортоор оруулж байгаа ойн аж ахуйн техник тоног төхөөрөмж, бордоо, ургамал хамгааллын бодис
2	Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай  /2013-06-07/	Импортоор оруулж байгаа туш чиглэлийн нимгэн давхартай хавтан /OSM/, стандартын дагуу хийгдсэн, угсрехад бэлэн модон барилгын угсармал хийц

Мөн 2008 онд батлагдсан Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулиар "импортоор оруулах беөрөнхий мод, гуалин, зүсмэл материал"-ыг гаалийн албан татвараас чөлөөлсөн байна.

Тус хуулиудыг хэрэгжүүлэх явцад мод, модон материалын импортын хэмжээ жил дараалан өсч ирсэн бөгөөд энэ хэмжээгээр ойгоос мод ашиглах, бэлтгэх хэмжээ буурч, ойг нөхөн сэргээх, цэцэрлэгжүүлэх ажлын цар хүрээ нэмэгдсэн байна.

Тухайлбал, Гаалийн ерөнхий газрын статистик мэдээллээс үзэхэд 2013 онд 23858.7m<sup>3</sup> мод, модон материал гаднаас импортолж байсан бол 2015 онд 34370.7m<sup>3</sup> болж 10.5m<sup>3</sup> – ээр буюу 1.5 %-иар өссөн байна.<sup>5</sup>

Барилга бүтээн байгуулалтын ажил эрчимтэй явагдаж байгаатай уялдан модлог шахмал хавтан үндсэн түүхий эд болох барилгын дотор хаалга, төрөл бүрийн тавилга, ламинатан шал, өнгөлсөн хавтангийн хэрэгцээ жилээс жилд нэмэгджээ. 2012 онд гэхэд 10 гаруй сая ам.долларын шахмал хавтан импортоор авсан бол 2016 онд 21 гаруй сая ам.долларын шахмал хавтан импортлосон байна.<sup>6</sup>

Түүнчлэн 2017 онд ойгоос бэлтгэх үйлдвэрлэлийн зориулалтын хэрэглээний модны хэмжээг 47,2 мянган шоометрээр тогтоосон нь 2013 оныхос даруй 40,7 хувиар бага байна.<sup>7</sup> Цаашид улам буурах хандлагатай байгаа нь гаалийн татварын хөнгөлөлттэй холбоотой юм.

<sup>4</sup> 2008 оны 05 дугаар сарын 29-ний өдөр батлагдсан Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль, 2013 оны 06 дугаар сарын 07-ны өдөр батлагдсан Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль.

<sup>5</sup> "Монгол Улсын ойн сан" Ойн неөцийн мэргэжлийн зөвлөлийн 2016.05.19-ний өдрийн хурлаар баталсан Монгол Улсын ойн сангийн тооллогын дүн.

<sup>6</sup> "Монгол Улсын ойн сан" Ойн неөцийн мэргэжлийн зөвлөлийн 2016.05.19-ний өдрийн хурлаар баталсан Монгол Улсын ойн сангийн тооллогын дүн.

<sup>7</sup> Байгаль орчин, ногоон хөгжлийн Сайдын 2012 оны А-145 дугаар тушаалын 2 дугаар хавсралт, БОАЖСайдын 2016 оны А/111 дүгээр тушаалын 01 дүгээр хавсралт.

Түүнчлэн нөхөн сэргээсэн, ойжуулалтын ажлын цар хүрээ нэмэгдэж, зөвхөн 2016 онд гэхэд 537,5 га<sup>8</sup>, 2017 онд 1001 га<sup>9</sup> талбайд ойг нөхөн сэргээх, ойжуулалтын ажил гүйцэтгэсэн байна.

Мөн импортоор оруулж байгаа туш чиглэлийн нимгэн давхаргатай хавтан /OSM/, стандартын дагуу хийгдсэн, угсрахад бэлэн модон барилгын угсармал хийцийг 2013 оны 6 дугаар сараас эхлэн гаалийн албан татвараас чөлөөлсөн боловч хуулийн үйлчлэх хугацаа 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дууссан нь<sup>10</sup> тус салбартаа сөрөг үр дагавар гарсан үүсгэхээр байна.

Тухайлбал, Төрөөс ойн талаар баримтлах бодлогын зорилтыг хангах, хэрэгжүүлэх үйл ажиллагааны тайлангийн<sup>11</sup> мэдээлэлд дүн шинжилгээ хийж үзвэл, улсын хэмжээнд ойг нөхөн сэргээх ажлыг 2015 онд 5717,7 га газарт хийж гүйцэтгэсэн бол 2016 онд 3435 га газар болж, 2282,7 га-гаар буурсан байна.<sup>12</sup>

Гэвч 2016 оны байдлаар улсын хэмжээнд 2731,1 мян.га талбайд 39967,1 мян.ш.м хатсан, 29914,3 мян.ш.м унанги модыг цэвэрлэх, 106,3 мян.га талбайд арчилгаа хийх, 530,4 мян.га талбайд ойжуулалт, 373,8 мян.га талбайд байгалийн сэргэн ургалтад туслах, 19,7 мян.га талбайд өсвөр модыг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай байна.<sup>13</sup>

Иймд импортоор оруулж байгаа туш чиглэлийн нимгэн давхаргатай хавтан /OSB/, стандартын дагуу хийгдсэн, угсрахад бэлэн модон барилгын угсармал хийцийг гаалийн албан татвараас чөлөөлөх эрх зүйн орчинг дахин бүрдүүлэх шаардлагатай байна.

#### **Хоёр.Хуулийн төслийн өрөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг шинээр боловсруулж, хуулийн төсөлд дараах зүйлийг тусгах шаардлагатай байна:

1. Импортоор оруулж байгаа туш чиглэлийн нимгэн давхаргатай хавтан /OSB/, стандартын дагуу хийгдсэн, угсрахад бэлэн модон барилгын угсармал хийцийг гаалийн албан татвараас чөлөөлөх зүйлд хамруулж, хуулийг хэрэгжүүлэх хугацааг тогтоох;
2. Гаалийн албан татвараас чөлөөлөгдөх материалын жагсаалтыг "Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем /БТКУС/-ийн ангиллын дагуу тогтоох эрх хэмжээг Засгийн газарт олгох.

#### **Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар**

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл батлагдснаар Ойн тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлж, улмаар "Төрөөс ойн талаар баримтлах бодлого" болон "Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны

<sup>8</sup> Төрөөс ойн талаар баримтлах бодлогын зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны тайлан. 2017 он.

<sup>9</sup> Байгаль орчин, аялал жуулчлалын яамны үйл ажиллагааны тайлан. 2018 он.

<sup>10</sup> Төрөөс ойн талаар баримтлах бодлогын зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны тайлан. 2017 он

<sup>11</sup> БОАЖЯ-ны тайлан. 2017 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр.

<sup>12</sup> Төрөөс ойн талаар баримтлах бодлогын зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны тайлан. 2017

<sup>13</sup> "Монгол Улсын ойн сан" Ойн нөөцийн мэргэжлийн зөвлөлийн 2016.05.19-ний өдрийн хурлаар баталсан Монгол Улсын ойн сангийн тооллогын дүн.

хөтөлбөр"-т заасан ойн санг хамгаалах, нөхөн сэргээх зорилтыг хангах нөхцөлийг бүрдүүлэх болно.

Түүнчлэн импортоор оруулж байгаа мод, модон материалын гаалийн албан татвараас чөлөөлснөөр төсвийн бурдуулэлтэнд бага хэмжээний алдагдал бий болох боловч байгаль орчныг хамгаалах чиглэлд олон давхар ач холбогдлыг авчирна.

Тухайлбал, модны импортын хэмжээ нэмэгдсэнээр модон бүтээгдэхүүний үйлдвэрлэл өсөж, тэр хэмжээгээр ой модны салбарын үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 300 гаруй аж ахуйн нэгж байгууллагын болон тухайн аж ахуйн нэгжид ажиллагсадын орлого, түүнчлэн төсөвт оруулах хувь хүний болон аж ахуйн нэгжийн орлогын татварын хэмжээ өсөх давуу талтай.

Мөн ойжуулалт, цэцэрлэгжүүлэлт, ойн ахуйн аж арга хэмжээний ажлыг гүйцэтгэх сонирхолтой аж ахуйн нэгжийн тоо нэмэгдэж, улмаар ой нөхөн сэргээх чанарын болон цар хүрээний өсөлт гарна.

Манай улсын хувьд зарим жил 20 сая гаруй ам. долларын мебель модон эдлэл гадаадын орнуудаас импортоор авч байгаа нь дотоодын үйлдвэрлэлээс 3-4 дахин илүү байна.

Иймд гадна мод, модон материалыг гаалийн албан татвараас чөлөөлснөөр импорт орлох мебель модон бүтээгдэхүүний үйлдвэрлэл өсч, импортын хэмжээ багасах тул гадагш урсах валютын хэмжээ зохих хэмжээгээр буурна хэмээн тооцож байна.

Хууль батлагдсаны дараа хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой улсын төсвөөс нэмэлт зардал шаардагдахгүй болно.

#### **Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах талаар**

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, хүний эрх, байгаль орчныг хамгаалах чиглэлээр Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, Татварын ерөнхий хууль болон Гаалийн тариф, гаалийн татварын хуультай нийцүүлэн боловсруулна.

----- оОо -----



## НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна." гэж, мөн зүйлийн 2 дахь хэсэгт "Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн өмч мөн." гэж тус тус заасан.

Түүнчлэн Улсын Их Хурлын 2010 оны "Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал батлах тухай" 48 дугаар тогтоолын хавсралтын 3.5.3.3-т "Байгалийн ургамал, ойн дагалт нөөцийн экспорт болон ойн үндсэн ашиглалтын огтлолтыг бүрэн хориглож, ойн сангийн нөөцийг 2 хувиар нэмэгдүүлнэ" гэж, 3.5.3.4-т "Мод орлох технологи нэвтрүүлэхийг дэмжих, энэ төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж түлшний асуудлыг цогц байдлаар шийдэх, мод, модон бүтээгдэхүүний импортыг нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлнэ." гэж тус тус тусгажээ.

Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2013 оны 14 дүгээр тогтоолоор Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал болон Ойн тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор импортоор мод, модон материал оруулж ирж үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийн бизнесийг дэмжих, нэмэгдсэн өртгийн болон гаалийн албан татвараас чөлөөлөх, тэдгээрт хөнгөлөлттэй зээл олгох арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасан байна.

Улсын Их Хурлын 2015 оны "Төрөөс ойн талаар баримтлах бодлого батлах тухай" 49 дүгээр тогтоолд ойн нөхөн сэргээлт, ойжуулалтын хэмжээг өсгөх замаар ойгоор бүрхэгдсэн талбайг нэмэгдүүлэх<sup>1</sup>, мод орлох бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийн зориулалттай мод, модон материалын хэрэгцээг импортын modoор хангах бодлого баримталж, иргэдийн модон бүтээгдэхүүний хэрэгцээг ойн арчилгаа, цэвэрлэгээний зэрэг ойн экосистемд халгуй аргаар бэлтгэсэн modoор хангах<sup>2</sup>, тарьц, суулгац ургуулах дэвшилтэт шинэ технологи нэвтрүүлж, ойжуулалтын ажлын чанарыг сайжруулах<sup>3</sup>, ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээнд оруулах хөрөнгө оруулалтыг дэмжих хөшүүрэг, механизмыг бий болгох зэрэг арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлэхээр заасан.

<sup>1</sup> Төрөөс ойн талаар баримтлах бодлогын 2.2.1 дахь заалт.

<sup>2</sup> Төрөөс ойн талаар баримтлах бодлогын 3.2.2. дахь заалт.

<sup>3</sup> Төрөөс ойн талаар баримтлах бодлогын 3.1.5, 3.4.2 дахь заалт.

Засгийн газрын санаачлагаар 2008-2016 онуудад Улсын Их Хурлаас ойг хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагааг дэмжих хүрээнд Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай (2008, 2013 онуудад) хуулийг<sup>4</sup> батлан хэрэгжүүлж иржээ.

Хууль	Татвараас чөлөөлөгдсөн зүйл
1 Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хууль /2013-06-07/ /2013.06.07-2017.12.31-ний өдрийг хүртэл хугацаанд чөлөөлсөн/	Ойжуулалт, цэцэрлэгжүүлэлт, ойн ахуйн аж арга хэмжээний ажил Импортоор оруулж байгаа туш чиглэлийн нимгэн давхаргатай хавтан /OSM/, беөрөнхий мод, гуалин, модон зүсмэл материал, стандартын дагуу хийгдсэн, угсрахад бэлэн модон барилгын угсармал хийц
2 Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай /2016-02-05/ /2016.01.01-2016.12.31-ний өдрийг хүртэл хугацаанд чөлөөлсөн/	Импортоор оруулж байгаа болон дотоодоо худалдан борлуулсан ойн аж ахуйн техник тоног төхөөрөмж, бордоо, ургамал хамгааллын бодис

Мөн 2016 онд батлагдсан Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулиар “импортоор оруулж байгаа беөрөнхий мод, гуалин, зүсмэл материал, банз, модон бэлдэц, хагас боловсруулсан модон материал”-ыг НӨАТ-аас чөлөөлсөн байна<sup>5</sup>.

Тус хуулиудыг хэрэгжүүлэх явцад мод, модон материалын импортын хэмжээ жил дараалан ессэн төдийгүй энэ хэмжээгээр ойгоос мод ашиглах, бэлтгэх, хууль бус мод бэлтгэлийн хэмжээ буурч, ойг нөхөн сэргээх, цэцэрлэгжүүлэх ажлын цар хүрээ нэмэгдсэн байна.

Тухайлбал, 2012 онд ойжуулалт, мод үржүүлгийн чиглэлээр ажилладаг аж ахуйн нэгжийн тоо 60 гаруй байсан бол 2016 оны байдлаар 2 дахин нэмэгдсэн байна. Түүнчлэн ойг нөхөн сэргээх ажлын цар хүрээ нэмэгдэж, зөвхөн 2016 онд гэхэд 537.5 га<sup>6</sup>, 2017 онд 1001 га<sup>7</sup> талбайд ойг нөхөн сэргээх, ойжуулалтын ажил гүйцэтгэсэн байна<sup>8</sup>.

Түүнчлэн 2017 онд ойгоос бэлтгэх үйлдвэрлэлийн зориулалтын хэрэглээний модны хэмжээг 47,2 мянган шоометрээр тогтоосон нь 2013 оныхос даруй 40,7 хувиар бага байна.<sup>9</sup> Цаашид улам буурах хандлагатай байгаа нь татварын хөнгөлөлттэй холбоотой байна.

Ойжуулалт, цэцэрлэгжүүлэлт, ойн ахуйн аж арга хэмжээний ажил, импортоор оруулж байгаа болон дотооддоо үйлдвэрлэж, худалдаалж байгаа туш чиглэлийн нимгэн давхаргатай хавтан /OSM/, стандартын дагуу хийгдсэн, угсрахад бэлэн модон барилгын угсармал хийцийг НӨАТ-аас чөлөөлөх хуулийн хугацаа

<sup>4</sup> 2008 оны 05 дугаар сарын 29-ний өдөр батлагдсан Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль, 2013 оны 06 дугаар сарын 07-ны өдөр батлагдсан Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль.

<sup>5</sup> Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.20 дахь заалт.

<sup>6</sup> Төрөөс ойн талаар баримтлах бодлогын зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны тайлан. 2017 он

<sup>7</sup> Байгаль орчин, аялал жуулчлалын яамны үйл ажиллагааны тайлан. 2018 он

<sup>8</sup> Байгаль орчин, аялал жуулчлалын яамны үйл ажиллагааны тайлан. 2016 он

<sup>9</sup> БОНХСайдын 2012 оны А-145 дугаар тушаалын 2 дугаар хавсралт, БОАЖСайдын 2016 оны А/111 дүгээр тушаалын 01 дүгээр хавсралт.

хориглосноос бусад мод, сөөгний үр, тарьц, суулгацыг НӨАТ-аас чөлөөлсөн зохицуулалт байхгүй байна.

Иймд ойг хамгаалах, нөхөн сэргээх зорилгоор хэрэгжүүлж байсан НӨАТ-ын чөлөөлөлтийн тодорхой хэсгийг зогсоосноос хойш сөрөг үр дагавар үүсгэхээр байна.

Тухайлбал, Төрөөс ойн талаар баримтлах бодлогын зорилтыг хангах, хэрэгжүүлэх үйл ажиллагааны тайлангийн<sup>10</sup> мэдээлэлд дүн шинжилгээ хийж үзвэл, улсын хэмжээнд ойг нөхөн сэргээх ажлыг 2015 онд 5717,7 га газарт хийж гүйцэтгэсэн бол 2016 онд 3435 га газар болж, 2282.7га-гаар буурсан байна.<sup>11</sup>

Гэтэл 2016 оны байдлаар улсын хэмжээнд 2731,1 мян.га талбайд 39967,1 мян.ш.м хатсан, 29914,3 мян.ш.м унанги модыг цэвэрлэх, 106,3 мян.га талбайд арчилгаа хийх, 530,4 мян.га талбайд ойжуулалт, 373,8 мян.га талбайд байгалийн сэргэн ургалтад туслах, 19,7 мян.га талбайд өсвер модыг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай байна.<sup>12</sup>

Иймд ойжуулалт, цэцэрлэгжүүлэлт, ойн ахуйн аж арга хэмжээний ажил, импортоор оруулж байгаа болон дотооддоо үйлвэрлэж, худалдаалж байгаа туш чиглэлийн нимгэн давхаргатай хавтан /OSM/, стандартын дагуу хийгдсэн, угсрахад бэлэн модон барилгын угсармал хийцийг НӨАТ-аас чөлөөлөх хуулийн хугацаа 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дууссан тул эдгээр ажил, материалыг НӨАТ-аас чөлөөлсөн зохицуулалт шаардлагатай байна.

#### **Хоёр. Хуулийн төслийн өрөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийн шинээр боловсруулж дараах зохицуулалтыг тусгах нь зүйтэй байна:

1. Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх зүйлд “ойжуулалт, цэцэрлэгжүүлэлт, ойн аж ахуйн арга хэмжээний ажил болон импортоор оруулж байгаа туш чиглэлийн нимгэн давхаргатай хавтан /OSB/, стандартын дагуу хийгдсэн, угсрахад бэлэн модон барилгын угсармал хийц”-ийг багтааж, хуулийг хэрэгжүүлэх хугацааг тогтоох;
2. Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөгдөх ойжуулалт, цэцэрлэгжүүлэлт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлын жагсаалтыг батлах эрх хэмжээг Засгийн газарт олгох.

#### **Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, здийн засаг, хууль зүйн үр дагавар**

“Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль батлагдснаар Ойн тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлж, улмаар “Төрөөс ойн талаар баримтлах бодлого” болон “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр” – т заасан ойн санг хамгаалах, нөхөн сэргээх зорилтыг хангах нөхцлийг бүрдүүлэх болно.

<sup>10</sup> БОАЖЯ-ны тайлан. 2017 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр.

<sup>11</sup> Төрөөс ойн талаар баримтлах бодлогын зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны тайлан. 2017

<sup>12</sup> “Ойн судалгаа, хөгжлийн төв” улсын төсөвт үйлдвэрийн газар. “Монгол орны ойн сан”. 2016 он.

Түүнчлэн мод, модон материалын импортын нэмэгдсэн өртгийн албан татвараас орох орлогын хэмжээ харьцангуй бага учир төсөвт сэргээр нэлөөлөхгүй.

Ойжуулалт, цэцэрлэгжүүлэлт, ойн ахуйн аж арга хэмжээний ажлыг гүйцэтгэх сонирхолтой аж ахуйн нэгжийн тоо нэмэгдэж, улмаар ойжуулах ажилд чанарын болон цар хүрээний өсөлт гарна.

Харин модны импортын хэмжээ нэмэгдсэнээр модон бүтээгдэхүүний үйлдвэрлэл өсөж, ой модны салбарын үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 300 гаруй аж ахуйн нэгж байгууллагын 3000 гаруй ажиллагсадын орлого, түүнчлэн төсөвт оруулах хувь хүний болон аж ахуйн нэгжийн орлогын татварын хэмжээ өсөх давуу талтай.

Өөрөөр хэлбэл, дотоодын үйлдвэрлэлээс 3-4 дахин илүү, зарим жил 20 сая гаруй ам.долларын мебель модон эдлэл гадаадын орнуудаас импортоор авч байна.

Иймд модон материалын импортын НӨАТ-ыг чөлөөлснөөр импорт орлох мебель модон бүтээгдэхүүний үйлдвэрлэл өсөж, импортын хэмжээ багасан гадагш урсах валютын хэмжээ зохих хэмжээгээр буурна гэж үзэж байгаа болно.

Хууль батлагдсаны дараа хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой нэмэлт зардал улсын төсвөөс шаардагдахгүй болно.

**Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах талаар**

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, хүний эрх, байгаль орчныг хамгаалах чиглэлээр Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, Татварын ерөнхий хууль болон Нэмэгдсэн өртгийн албан татварын хуульд нийцүүлэн боловсруулна.

----- оОо -----

## ТАНИЛЦУУЛГА

### Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл

Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.5.3.3-д “Байгалийн ургамал, ойн дагалт нөөцийн экспорт болон ойн үндсэн ашиглалтын огтполтыг бүрэн хориглож, ойн сангийн нөөцийг 2 хувиар нэмэгдүүлнэ”, 2015 оны 49 дүгээр тогтоолоор баталсан “Төрөөс ойн талаар баримтлах бодлого” –ын 3.1.5-д “ойгоос олгох модны хэмжээг үе шаттай бууруулж, мод орлох бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийн зориулалттай мод, модон материалын хэрэгцээг импортын modoор хангах бодлого баримталж, иргэдийн модон бүтээгдэхүүний хэрэгцээг ойн арчилгаа, цэвэрлэгээний болон түүвэрлэх огтполт зэрэг ойн экосистемд халгүй аргаар бэлтгэсэн modoор хангах” гэж тус тус заасныг хэрэгжүүлэхэд ойжуулалт, цэцэрлэгжүүлэлт, ойн аж ахуйн арга хэмжээний ажил, болон импортоор оруулж байгаа мод орлох бүтээгдэхүүн, модон барилгын хийцийг татвараас чөлөөлөх шаардлага тулгарч байна.

2013 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулиар Ойжуулалт, цэцэрлэгжүүлэлт, ойн аж ахуйн арга хэмжээний ажил болон импортоор оруулж байгаа туш чиглэлийн нимгэн давхаргатай хавтан /OSM/, стандартын дагуу хийгдсэн, угсрехад бэлэн модон барилгын угсармал хийцийг 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл тус тус гаалийн албан татвараас чөлөөлсөн байдаг.

Гаалийн ерөнхий газрын статистик мэдээллээс үзэхэд 2013 онд  $23858.7\text{m}^3$ <sup>3</sup> мод, модон материал гаднаас имортолж байсан бол 2015 онд  $34370.7\text{m}^3$  болж  $10.5\text{m}^3$  – ээр буюу 1.5%-иар өссөн байна. 2017 онд ойгоос бэлтгэх үйлдвэрлэлийн зориулалтын хэрэглээний модны хэмжээг 47,2 мянган шоометрээр тогтоосон нь 2013 оныхоос даруй 40,7 хувиар бага байгаа, цаашид буурах хандлагатай байгаа нь ч татварын хөнгөлөлттэй шууд холбоотой юм.

Экологи, нийгэм, эдийн засгийн ач холбогдол бүхий дээрх хуулийн үйлчлэх хугацаа дуусгавар болсон тул Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагыг ханган боловсруулан танилцуулж байна. Үүнд:

- Ойжуулалт, цэцэрлэгжүүлэлт, ойн аж ахуйн арга хэмжээний ажил болон Импортоор оруулж байгаа туш чиглэлийн нимгэн давхаргатай /OSB/, стандартын дагуу хийгдсэн, угсрехад бэлэн модон барилгын угсармал хийцийг гаалийн албан татвараас чөлөөлөхөөр тусгасан болно.

## ТАНИЛЦУУЛГА

### Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл

Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.5.3.3-д “Байгалийн ургамал, ойн дагалт нөөцийн экспорт болон ойн үндсэн ашиглалтын огтлолтыг бүрэн хориглож, ойн сангийн нөөцийг 2 хувиар нэмэгдүүлнэ”, 2015 оны 49 дүгээр тогтоолоор баталсан “Төрөөс ойн талаар баримтлах бодлого” –ын 3.1.5-д “ойгоос олгох модны хэмжээг үе шаттай бууруулж, мод орлох бүтээгдэхүүний нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийн зориулалттай мод, модон материалын хэрэгцээг импортын modoор хангах бодлого баримталж, иргэдийн модон бүтээгдэхүүний хэрэгцээг ойн арчилгаа, цэвэрлэгээний болон түүвэрлэх огтлолт зэрэг ойн экосистемд халгүй аргаар бэлтгэсэн modoор хангах” гэж тус тус заасныг хэрэгжүүлэхэд ойжуулалт, цэцэрлэгжүүлэлт, ойн аж ахуйн арга хэмжээний ажил, болон импортоор оруулж байгаа мод орлох бүтээгдэхүүн, модон барилгын хийцийг татвараас чөлөөлөх шаардлага тулгарч байна.

2013 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн “Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай” хуулиар Ойжуулалт, цэцэрлэгжүүлэлт, ойн ахуйн аж арга хэмжээний ажил болон импортоор оруулж байгаа тууш чиглэлийн нимгэн давхаргатай хавтан /OSM/, бөөрөнхий мод, гуалин, модон зүсмэл материал, стандартын дагуу хийгдсэн, угсрехад бэлэн модон барилгын угсармал хийцийг нэмэгдсэн өртгийн албан татвараас 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлсөн.

Дээрх хуулиудыг хэрэгжүүлэх явцад мод, модон материалын импортын хэмжээ жил дараалан өсч ирсэн бөгөөд энэ хэмжээтээр ойгоос ашиглах, бэлтгэх мод, хууль бус мод бэлтгэлийн хэмжээ буурч, ойг нөхөн сэргээх, цэцэрлэгжүүлэх ажлын цар хүрээ нэмэгдсэн байна.

Экологи, нийгэм, эдийн засгийн ач холбогдол бүхий дээрх хуулиудын үйлчлэх хугацаа дуусгавар болсон тул Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагыг ханган боловсруулан танилцуулж байна. Үүнд:

- Ойжуулалт, цэцэрлэгжүүлэлт, ойн аж ахуйн арга хэмжээний ажил болон импортоор оруулж байгаа тууш чиглэлийн нимгэн давхаргатай хавтан /OSB/, стандартын дагуу хийгдсэн, угсрехад бэлэн модон барилгын угсармал хийцийг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөхөөр тусгасан болно.

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны . . дугаар  
сарын . . -ны өдөр

Улаанбаатар хот

### ГААЛИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Импортоор оруулж байгаа туш чиглэлийн нимгэн давхаргатай хавтан /OSB/, стандартын дагуу хийгдсэн, угсархад бэлэн модон барилгын угсармал хийцийг гаалийн албан татвараас 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд тус тус чөлөөлсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан барааны жагсаалтыг "Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем /БТКУС/-ийн ангиллын дагуу Засгийн газар батална.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг батлагдсан өдрөөс буюу 2018 оны ... дугаар сарын... -ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны . . дугаар  
сарын . . -ны өдөр

Улаанбаатар хот

### НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Ойжуулалт, цэцэрлэгжүүлэлт, ойн аж ахуйн арга хэмжээний ажил болон импортоор оруулж байгаа тууш чиглэлийн нимгэн давхаргатай хавтан /OSB/, стандартын дагуу хийгдсэн, угсрахад бэлэн модон барилгын угсармал хийцийг нэмэгдсэн өртгийн албан татвараас 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд тус тус чөлөөлсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан ойжуулалт, цэцэрлэгжүүлэлт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлын жагсаалт болон импортоор оруулж байгаа барааны жагсаалтыг "Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем /БТКУС/-ийн ангиллын дагуу Засгийн газар батална.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг батлагдсан өдрөөс буюу 2018 оны ... дугаар сарын... -ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг